



ХАСБАНК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20 **25** оны **04** сарын **29** өдөр

№ SR-2025-04

Улаанбаатар хот

ХасБанк ХК-ийн Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

ХасБанк ХК (“Банк”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

- Санхүүгийн Зохицуулах Хороо (“СЗХ”) нь Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайланг хянан баталгаажуулахдаа Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.5 болон 81.6 дахь хэсэгт тус тус заасныг үндэслэн нэр дэвшүүлэх чиг үүргийг цалин урамшууллын чиг үүргээс тусгаарлах зөвлөмжийг ирүүлсэн болохыг;
- Төлөөлөн удирдах зөвлөл (“ТҮЗ”) Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороог: (а) ТҮЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх, залгамж халааг төлөвлөн зохион байгуулах чиг үүрэг бүхий Нэр дэвшүүлэх хороо болон (б) компанийн засаглалын бодлого журам, ТҮЗ-ийн бүтэц, цалин хөлслний бодлого, урамшууллын бүтцийг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий Засаглал, цалин урамшууллын хороо болгон бие даасан хоёр хороонд хувааж өөрчлөн байгуулах асуудлыг тусгаж Банкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахыг R-2025-08 тоот тогтоолоороо зөвлөмж болгосныг; мөн
- ТҮЗ-өөс зөвлөмж болгосны дагуу, Хувьцаа эзэмшигчид Банкны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- Дээр дурдсаныг үндэслэн, Банкны Дүрмийн дараах хэсгүүдэд доорх нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай:

Одоогийн заалт	Нэмэлт, өөрчлөлт оруулсан заалт
8.14. ТҮЗ-ийн гишүүдийн 1/3 (гуравны нэг)-ээс доошгүй нь ТҮЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооноос тус бүрийг сонгон нэр дэвшүүлсэн, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанк, СЗХ-ноос заасан шаардлагыг хангасан хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүн нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад Холбогдох хууль тогтоомжид, үүний дотор зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүйгээр Монголбанк, СЗХ, МХБ-ээс баталсан холбогдох бусад	8.14. ТҮЗ-ийн гишүүдийн 1/3 (гуравны нэг)-ээс доошгүй нь ТҮЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооноос Нэр дэвшүүлэх хорооноос тус бүрийг сонгон нэр дэвшүүлсэн, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанк, СЗХ-ноос заасан шаардлагыг хангасан хараат бус гишүүн нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад Холбогдох хууль тогтоомжид, үүний дотор зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүйгээр Монголбанк, СЗХ, МХБ-ээс баталсан холбогдох бусад

дүрэм, журамд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.	дүрэм, журамд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.
8.29. ТУЗ нь Аудитын, Эрсдэлийн удирдлагын, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн эсхүл Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу байгуулах шаардлагатай бусад хороодтой байна (дангаар нь “Хороо”, хамтад нь “Хороод” гэх). ТУЗ нь өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг хороогоор дамжуулан хэрэгжүүлж болох бөгөөд үүнийг хорооны дүрмээр зохицуулна.	8.29. ТУЗ нь <u>Аудитын, Эрсдэлийн удирдлагын, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын болон</u> ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн эсхүл Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу байгуулах шаардлагатай бусад хороодтой байна (дангаар нь “Хороо”, хамтад нь “Хороод” гэх). ТУЗ нь өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг хороогоор дамжуулан хэрэгжүүлж болох бөгөөд үүнийг хорооны дүрмээр зохицуулна.
8.30. Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэгт заасны дагуу Аудитын болон Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүдийн 2/3 (гуравны хоёр)-оос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.	8.30. Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэгт заасны дагуу Аудитын, <u>бөлөн Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хөрөөны Нэр дэвшүүлэх болон Засаглал, цалин урамшууллын хорооны</u> гишүүдийн 2/3 (гуравны хоёр)-оос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.
8.40. Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын болон Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны гишүүн байхыг хориглох ба Гүйцэтгэх захирлыг томилох, сонгох болон чөлөөлөх асуудлаар шийдвэр гаргах, түүнд эрх хэмжээ олгох асуудлаар шийдвэр гаргах болон түүний ажлын гүйцэтгэл хэлэлцэх асуудалд саналын эрхгүй байна.	8.40. Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын <u>бөлөн Засаглал, нэр дэвшүүлэх, Нэр дэвшүүлэх</u> болон <u>Засаглал</u> , цалин урамшууллын хорооны гишүүн байхыг хориглох ба Гүйцэтгэх захирлыг томилох, сонгох болон чөлөөлөх асуудлаар шийдвэр гаргах, түүнд эрх хэмжээ олгох асуудлаар шийдвэр гаргах болон түүний ажлын гүйцэтгэл хэлэлцэх асуудалд саналын эрхгүй байна.

2. Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Монголбанк болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт Банкны нэрийн өмнөөс холбогдох аливаа баримт бичгийн хамт хүргүүлж, бүртгүүлэхийг Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Мөнхцэлмэгт даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГУПТА